



АГУУЛГА



1

КОМПАНИЙН ТУХАЙ

Эрхэм зорилго, үнэт зүйлс
Товч танилцуулга



2

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА

Компанийн засаглал
Компанийн нийгмийн хариуцлагын бодлого
Оролцогч, сонирхогч талуудын хамтын ажиллагаа
Өргөдөл, гомдол барагдуулах механизм
Орон нутгийн хөгжилд оруулж буй хувь нэмэр
Төсөл, хөтөлбөрүүд



3

АЖЛЫН БАЙР

Хүний нөөцийн бодлого, баримтлах зарчим
Ажлын байр, тэгш боломж
Нийгмийн халамж
Шилжилт хөдөлгөөн
Сургалт, хөгжил



4

БАЙГАЛЬ ОРЧИН

Байгаль орчны бодлого, баримтлах зарчим
Үйл ажиллагаа



5

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ

Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн бодлого,
баримтлах зарчим
Үйл ажиллагаа



6

ТОВЧ ДҮГНЭЛТ

ЭРХЭМ ЗОРИЛГО

Бид орчин үеийн техник, технологийг мэргэшсэн боловсон хүчний ур чадвар, хүсэл тэмүүлэлтэй хослуулан Монгол Улсын хөгжил, эдийн засгийн өсөлтөнд хувь нэмрээ оруулна.

АЛСЫН ХАРАА

Бид олон улсын зах зээл дээр нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн хэмжээний үйл ажиллагаатай үйлдвэрлэгч компани болно.

ҮНЭТ ЗҮЙЛС

Ажиллагсад, боловсон хүчин манай компанийн амин чухал зүйл гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн орчинд нэн тэргүүнд анхаарна.
- Энержи Ресурс ХХК нь ур чадвар, ажлын үр дүнг харгалзсан хөдөлмөр эрхлэлтийн адил тэгш боломжоор хангаж хариуцлагатай ажил олгогч байна.

Орчин үеийн өндөр үр өгөөжтэй техник технологи нь Монгол Улсад хөгжил дэвшил авчирна гэдэгт бид итгэдэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь сайн чанарын бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дэлхийн түвшний нүүрсний уурхай байгуулж хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь Монгол Улсын нүүрс олборлолтын салбарт техникийн шинэ стандарт тогтоохыг зорино.

Бид байгаль орчны хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК-ийн уурхай, дагалдах инженерийн бүтцийг байгаль орчинд аль болохоор бага нөлөөлөл учруулахаар зохион байгуулна.
- Энержи Ресурс ХХК нь шаардлагатай бүх байгаль орчны стандартуудыг мөрдөж, байгаль орчинд учирч болзошгүй нөлөөллийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээнүүдийг авна.

Бид нийгмийн хариуцлагатай уурхайн үйл ажиллагаа явуулдаг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь иргэдэд чиглэсэн бодлого, хөтөлбөрүүдээр дамжуулан нийгмийн хөгжилд хувь нэмрээ оруулна.

Компанийн сайн засаглал нь Энержи Ресурс ХХК-ийг ажиллуулах, удирдах, хяналтыг хэрэгжүүлэх үзэл баримтлал гэж бид үздэг, иймд:

- Энержи Ресурс ХХК нь олон улсын шилдэг туршлагыг үйл ажиллагаандаа нэвтрүүлнэ.
- Энержи Ресурс ХХК нь компанийн засаглалын соёлыг байгууллагынхаа хөгжлийн салшгүй хэсэг болгон мөрдөнө.

КОМПАНИЙН ТУХАЙ



ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Энержи Ресурс ХХК нь 2005 онд байгуулагдсан үндэсний хөрөнгө оруулалттай уул уурхайн компани бөгөөд Өмнөговь аймгийн Цогтцэций сумын нутаг дахь Ухаа Худаг нүүрсний уурхайд үйл ажиллагаа явуулдаг.

Тус компани нь 2009 оноос Ухаа Худагийн хөндийд томоохон бүтээн байгуулалтын ажлуудыг өрнүүлж эхэлсэн. Алслагдсан говь нутагт маш богино хугацаанд монгол инженер, техникийн ажилтнуудын хамтын хүчээр нүүрс баяжуулах үйлдвэр болон 18 мегаваттын цахилгаан станц, хатуу хучилттай авто зам, усан хангамжийн систем, 650 айлын орон сууцны хороолол, 700 хүүхдийн багтаамжтай сургууль, цэцэрлэг зэрэг дэд бүтцийн томоохон байгууламжуудыг барьж ашиглалтад оруулан, дэлхийн жишигт нийцсэн, уул уурхайн цогцолборыг бий болгосон.

Энержи Ресурс нь 2010 оны 10-р сард Монголын үндэсний компаниудаас анх удаа Хонконгийн хөрөнгийн биржид амжилттай IPO хийж, олон улсын хөрөнгийн зах зээлд хувьцаагаа гаргасан нээлттэй хувьцаат компани бөгөөд хувьцааны хяналтын багцыг үндэсний хөрөнгө оруулагчид эзэмшдэг.

Өнгөрсөн арван жилийн хугацаанд компани нийт 1.3 их наяд орчим төгрөгийг уурхайн болон дагалдах дэд бүтцийн төслүүдийн хөрөнгө оруулалтанд зарцуулсан төдийгүй 900 гаруй тэрбум төгрөгийг татвар, шимтгэл хэлбэрээр улсын төсөвт төвлөрүүлжээ.

Компани байгуулагдсан цагаасаа хойш орон нутгийн иргэдтэй “сайн хөрш”-ийн харилцааг хөгжүүлж, нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлэг зохион байгуулах замаар олон нийтийн санал бодлыг төсөл хэрэгжилтийн явцад тусгаж ирсэн бөгөөд жил бүр ойролцоогоор нэг тэрбум гаруй төгрөгийг зөвхөн орон нутгийг хөгжүүлэх, чадавхижуулах төсөл, хөтөлбөрүүдэд зарцуулж ирсэн.

Энержи Ресурс компани нь нэмүү өртөг шингэсэн, сайн чанарын коксжих нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүнээр олон улсын зах зээлд өрсөлдөн, Монгол Улсын хөгжил, дэвшил, үйлдвэржилтэд бодитой хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГА



КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

Энержи Ресурс компани нь олон улсын хөрөнгийн зах зээлд хөл тавьсан хувьцаат компани гэдэг утгаараа компанийн засаглалыг байгууллагын хөгжлийн чухал үзэл баримтлал гэж үздэг бөгөөд хувь нийлүүлэгчдийн эрх ашиг, тэдгээртэй адил тэгш харьцах зарчим болон мэдээллийн ил тод байдлыг хангах чиглэлд онцгой анхаарч ирсэн.

Компанийн сайн засаглалыг төлөвшүүлэх нь манай компанийн хувьд дэлхийн жишигт нийцсэн уул уурхайн үйлдвэрлэлийн цогцолбор байгуулан, улсдаа тэргүүлэгч аж ахуйн нэгж байх гол тулгуур хүчин зүйл гэж бид үздэг.

Энэ бодлогын хүрээнд дотоодын болон олон улсын сайн засаглалын шаардлага, стандартуудыг мөрдөхийн зэрэгцээ шийдвэр гаргалтын оновчтой, энгийн, түргэн шуурхай орчныг бүрдүүлэх байдлаар дотоод дүрэм, журмуудын хэрэгжилтийг ханган ажилладаг.

Бид хүний эрхийг дээдэлж, үйл ажиллагааныхаа хүрээнд орон нутгийн иргэдийн болон ажиллагсдынхаа эрхийг зөрчихгүй байх талаар анхаарч ажилладаг төдийгүй хүний эрхийн эрсдлийн үнэлгээг хийж, түүний дагуу хөтөлбөр боловсруулж, сургалт зааварчилгааг холбогдох ажиллагсаддаа тогтмол өгдөг.

Компанийн Ёс зүйн код нь ажлын байран дээрх ялгаварлан гадуурхалт, ашиг сонирхлын зөрчил, авилга хээл хахууль зэрэг зүй зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор ажиллагсад удирдамж, зааварчилгаа болдог. Энэхүү Ёс зүйн кодын хүрээнд ажиллагсад болон бусад оролцогч талууд бизнесийн ёс зүйн өндөр стандартыг баримтлан ажиллаж бүхий л төрлийн зохисгүй үйлдлээс урьдчилан сэргийлэх, улмаар таслан зогсоохыг эрмэлздэг.

Түүнчлэн оролцогч, сонирхогч талуудын итгэлийг хүлээх үүднээс нээлттэй, ил тод үйл ажиллагаа явуулахыг эрхэмлэн ажилладаг. Энэ хүрээнд үйл ажиллагаагаа олон нийт, хөрөнгө оруулагчид болон бусад төр засаг, олон улсын банк санхүүгийн байгууллагуудад нээлттэй тайлагнасаар ирсэн.

2009 онд үйл ажиллагаагаа эхлүүлснээс хойш Олборлох Үйлдвэрлэлийн Ил Тод Байдлын Санаачилга (ОУИТБС)-д нэгдэн, төр засгийн байгууллагад төлсөн төлбөр, татвар хураамжаа жил бүр ил тод, нээлттэй тайлагнаж, хариуцлагатай уул уурхайг хөгжүүлэх үйлсэд нэгдэн ажиллаж байна.

КОМПАНИЙН НИЙГМИЙН ХАРИУЦЛАГЫН БОДЛОГО

Энержи Ресурс компанийн хувьд Компанийн нийгмийн хариуцлага (КНХ) гэх ойлголтыг дан ганц хандив, тусламж юмуу богино хугацааны төсөл, хөтөлбөрүүд гэх мэт хязгаарлагдмал хүрээнд авч үздэггүй бөгөөд олон улсын болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжуудын хүрээнд хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлж, нийгмийн сайн сайхан, улс орны эдийн засгийн хөгжилд урт хугацааны, бодитой хувь нэмэр оруулах замаар тогтвортой хөгжлийн бат бэх суурь бий болгохыг зорьдог.

Иймд Олон Улсын Стандартын Байгууллагаас 2010 оны 10-р сард гаргасан “ISO26000: Нийгмийн хариуцлагын зөвлөмж” болон Олон Улсын Санхүүгийн Корпораци, Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк зэрэг байгууллагуудаас гаргасан удирдамжуудад үндэслэн КНХ-ын бодлогоо боловсруулан батлуулж, үйл ажиллагаандаа тусган хэрэгжүүлж байна.

Орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих,

нийгмийн суурь бүтцүүдийг тогтворжуулахад дэмжлэг үзүүлэх зорилгын хүрээнд дэд бүтэц, эрүүл мэндийн үйлчилгээний хүртээмжийг сайжруулах, боловсролыг дэмжих, соёлын өвийг хамгаалах, жижиг дунд бизнесийг дэмжих үндсэн чиглэлүүдээр төсөл, хөтөлбөрүүд хэрэгжүүлж байна.

Энэхүү хөтөлбөр, төслийн хүрээнд иргэд, оролцогч талуудтай зөвлөлдөх, компанийн үйл ажиллагааны талаар үнэн зөв мэдээллийг түгээх, орон нутгийн иргэд, оролцогч талуудаас ирсэн санал гомдлыг барагдуулахад анхааран ажилладаг.

Өнөөдөр тус компани нь уул уурхайн салбарын хэмжээнд КНХ хэрэгжүүлэгч шилдэг компанийн нэгээр зүй ёсоор нэрлэгдэж, оролцогч талуудынхаа итгэлийг хүлээн, нийгмийн зөвшөөрлөө ханган, улс орны болон орон нутгийн тогтвортой хөгжилд бодит хувь нэмрээ оруулан ажиллаж байна.

ОРОЛЦОГЧ, СОНИРХОГЧ ТАЛУУДЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА



Компани нь оролцогч болон сонирхогч талуудтай харилцан ашигтай хамтын ажиллагааг бий болгох, мэдээлэл туршлага солилцох, үйл ажиллагаандаа хөндлөнгийн мониторинг үнэлгээ хийлгэх, үйл ажиллагаагаа тайлагнах зэргээр гадаад дотоодын олон байгууллагатай үр өгөөжтэй хамтран ажилладаг. Энержи Ресурс компани нь оролцогч, сонирхогч талуудыг татан оролцуулах төлөвлөгөөг 2009 оноос

эхлэн хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү төлөвлөгөөнд дараах үндсэн зарчмуудыг тусгасан байдаг:

- Орон нутгийн иргэд Ухаа Худаг төслийн талаар мэдээлэл авах эрхийг хангаж ажиллах;
- Бодлого, төлөвлөлтөндөө оролцогч, сонирхогч талуудын санал хүсэлтийг тусгах зарчмыг баримтлан, үрдүнтэй хэлэлцүүлгийг аливаа шахалт дарамтгүйгээр, шударгаар явуулах;
- Үйл ажиллагааныхаа нийт хугацааны туршид оролцогч, сонирхогч талуудын оролцоог хангах чиглэлийн үйл ажиллагааг тогтмол явуулах;
- Иргэдийн санал хүсэлт, гомдлыг хүлээн авах, шийдвэрлэх механизмыг бий болгон хэрэгжүүлэх.

Эдгээр зарчмуудын хүрээнд компанийн үйл ажиллагааны талаар үнэн, зөв мэдээлэл түгээж, иргэдтэй нүүр тулж уулзан, тэдний санал зөвлөмжийг үйл ажиллагаандаа тусгах зорилгоор Монголын уул уурхайн салбарт анх удаа Орон нутгийн нээлттэй өдөрлөг, хэлэлцүүлгийг 2009 оноос эхлэн жил тутам зохион байгуулж ирсэн.

Мөн орон нутгийн иргэдтэй нээлттэй харилцааг

хөгжүүлж, шийдвэр гаргах явцад тэдний оролцоог хангах, дуу хоолойг тусгах үүднээс Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумдад орон нутгийн сайн дурын зөвлөл (ОНЗ) байгуулан тууштай хамтран ажиллаж байна.

Компаниас тус ОНЗ-тэй сар бүр уулздаг бөгөөд зөвлөл тус бүр малчид, өрх толгойлсон эмэгтэйчүүд, сумын ИТХ-ын гишүүд, орон нутгийн төрийн бус байгууллагууд болон хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмадын төлөөлөл зэрэг 9-11 хүний бүрэлдэхүүнтэйгээр ажилладаг. Ингэснээр ОНЗ нь нутгийн иргэдийн дуу хоолой болж, тэдний санал зөвлөмжийг компанид уламжлах замаар компани болон иргэдийн хооронд нээлттэй, эрх тэгш оролцоог хангах, хамтын ажиллагаа хөгжих боломжийг нэмэгдүүлж байна. 2017 онд

Цогтцэций сумын ИТХ-д хүсэлт гарган тус сумын ОНЗ-ийг шинэчлэн байгуулах тогтоол гаргуулснаар зөвлөлийн 9 гишүүнийг шинээр сонгож, улмаар 3 удаагийн хурлыг зохион байгуулсан.

Малчид, иргэдийг компанийн бүтээн байгуулалтын ажлууд болон байгаль орчны мониторинг, гар худаг болон тоосны хэмжилт, нөхөн сэргээлтийн ажилд сайн дураараа хяналт тавих байдлаар тогтмол оролцуулдаг нь компани ба иргэд хоорондын харилцан ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд эергээр нөлөөлж байна. Тайлант онд нийт 206 удаа гар худгийн хэмжилт, 120 цэгт тоосны мониторинг хийсэн бөгөөд хэмжилтийн үйл явцад орон нутгийн иргэдийг төлөөлж нийт 32 хүн оролцсон байна.

ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ БАРАГДУУЛАХ МЕХАНИЗМ



Жил ирэх тусам орон нутгийн иргэдээс ирэх гомдлын тоо эрс багасч, санал хүсэлтийн тоо нэмэгдэж байна

Компанийн үйл ажиллагааны улмаас хүний эрх, эрүүл мэнд, аюулгүй байдал, байгаль орчинд үүсч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг тухай бүр илрүүлж, цаг тухайд нь арга хэмжээ авч байх зорилгоор орон нутгийн иргэд болон ажиллагсдаас ирсэн гомдлыг хүлээн авч шуурхай шийдвэрлэж эргэн мэдээлэх журмыг хэрэгжүүлэн ажилладаг. Энэ журмын хүрээнд аливаа өргөдөл, гомдол, хүсэлтийг хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор хариу өгч, шаардлагатай болон хүсэлт гаргасан тохиолдолд гомдлын нууцлалыг хадгалах ба бүх гомдолд ижил тэгш зарчмаар ханддаг. Өргөдөл гомдол, санал хүсэлтийг утсаар, цахим шуудангаар, бичгээр болон иргэдтэй биечлэн уулзах байдлаар хүлээн авдаг.

2017 онд компанийн хэмжээнд нийт 52 хүсэлт, 1 гомдол хүлээн авсан байна. Эдгээр хүсэлтийн 45% нь компаниас санхүү, эд материалын хандив тусламж хүсэх тухай, 14% нь Ухаа Худаг уурхай болон “Галерей” кэмийн үйл ажиллагаатай танилцах тухай, 13% нь бараа, бүтээгдэхүүн нийлүүлэх, гэрээ байгуулах, хамтран ажиллах, ажилд орох тухай, 12% нь худаг устай холбоотой, үлдсэн 2% нь орон сууцанд хамрагдах зэрэг хүсэлтүүд байлаа. Нэг гомдол нь малчин Ц.Соёлтоос ирүүлсэн худаг устай холбоотой байсан бөгөөд энэ дагуу Хармагтайн гар худгийг сэргээн засварлаж, лагийг laidан шавхаж, өрөмдөн өгч гомдлыг барагдуулсан. Бүх саналыг 30 хоногийн дотор шийдвэрлэж, тухай бүр хариу мэдээлсэн байна. Нийт өргөдлийн 64 хувийг Цогтцэций сумын харъяат иргэд, байгууллагуудаас ирүүлжээ.


Жил ирэх тусам ард иргэдээс ирэх гомдлын тоо эрс багасч, санал хүсэлтийн тоо нэмэгдэж байгаа нь компанийн зүгээс хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг бодитой хэрэгжүүлж, нээлттэй, олон талт харилцааг хөгжүүлэн ажиллаж ирсний бодит үр дүн юм.

Цаашид “Иргэд, хуулийн этгээдээс гаргасан санал гомдол шийдвэрлэх журам”-ын хамрах хүрээг илүү өргөжүүлж гадаад болон дотоод оролцогч талын санал гомдол шийдвэрлэх, сэтгэл ханамжийг судлах чиглэлээр журамд өөрчлөлт, шинэчлэлт оруулахаар төлөвлөж байна.

ОРОН НУТГИЙН ХӨГЖИЛД ОРУУЛЖ БУЙ ХУВЬ НЭМЭР

Энержи Ресурс компани нь 2009 онд үйл ажиллагаа эхлүүлснээс хойш татвар төлөлт, эдийн засагт оруулж буй хувь нэмрийн хэмжээгээр Монгол Улсын ТОП 5 аж ахуйн нэгжээр тогтмол шалгарч, улс орны хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулж ирсэн. Тодруулбал, 2009-2017 он хүртэлх арван жилийн хугацаанд нийт 906 тэрбум төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна. 2017 онд татвар, шимтгэл хэлбэрээр нийт 87 тэрбум төгрөгийн татварыг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Улсын төсөвт оруулсан татварын дүн
(тэрбум төгрөгөөр)



Орон нутаг төдийгүй улс орны хэмжээнд хөгжлийн чухал хөшүүргүүдийн нэг нь дэд бүтцийн асуудал байдаг. Энержи Ресурс компани үйл ажиллагаа явуулж эхэлснээс хойш Ухаа Худагт өргөн цар хүрээтэй бүтээн байгуулалтыг өрнүүлж, уурхай дагасан дэд бүтцийн шийдлийг цогцоор бүрдүүлсэн. Тухайлбал, Монгол инженерүүдийн ур ухаанаар дулааны цахилгаан станц, усан хангамжийн систем барьж байгуулснаар орон нутгийн иргэд 24 цагийн найдвартай эрчим хүч, цэвэршүүлсэн усаар хангагдах болсон.

Мөн орон сууцны “Цэций” хороолол, сургууль цэцэрлэгийн “Мөрөөдөл” цогцолборыг барьж байгуулснаар ажиллагсад болон орон нутгийн иргэд ая тухтай амьдрах, хүүхэд багачууд говийн алслагдмал суманд ч тохилог орчинд, чанартай боловсрол олж авах нөхцөл боломж бүрдсэн.

Тайлант онд нийт 4.7 тэрбум төгрөгийг орон нутгийн дэд бүтэц болон орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжихэд чиглэсэн төсөл хөтөлбөрүүд, холбогдох бусад ажлуудад зарцуулсан байна. Орон нутгийн тогтвортой хөгжил, эдийн засгийг дэмжих нэг хэлбэр нь орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдээс бараа бүтээгдэхүүн худалдан авах явдал юм. Компанийн зүгээс бараа бүтээгдэхүүн худалдан авахдаа бизнесийн шударга зарчмыг баримталж, орон нутгийн бизнес эрхлэгчидтэй хамтрахыг нэн тэргүүнд зорьдог.

Өнгөрсөн онд нийт 280 аж ахуйн нэгжээс хэрэгцээт бараа, үйлчилгээ худалдан авсны 74 хувь нь үндэсний компаниуд байсан бол Өмнөговь аймаг буюу орон нутгийн хэмжээнд 25 аж ахуйн нэгжээс нийт 1.1 тэрбум төгрөгийн бараа материал, ажил үйлчилгээний худалдан авалт хийжээ.

Орон нутагт хийсэн хөрөнгө оруулалт
(тэрбум төгрөгөөр)



Хөрөнгө оруулалтын чиглэл	/мянган төгрөгөөр/
1. Орон нутгийн дэд бүтцийн хөгжил	2,164,143
2. Орон нутгийн хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүд	939,866
3. Хандив, тусламж	520,248
4. Орон нутгийн худалдан авалт	1,100,000
Нийт	4,724,257

ТӨСӨЛ, ХӨТӨЛБӨРҮҮД

Энержи Ресурс компани нь боловсрол, хүн ам, эрүүл мэнд, хүний эрх, соёлын өв зэрэг нийгмийн олон чиглэлийн суурь судалгаа болон иргэдийн нээлттэй хэлэлцүүлгийн санал санаачлагыг үндэслэн орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдийг орон нутгийн иргэд, олон нийт болон засаг захиргааны байгууллагуудтай хамтран хэрэгжүүлдэг.

Мөн иргэд, засаг захиргааны байгууллага, харилцагч, нийлүүлэгчидтэй “сайн хөрш”-ийн харилцааг эрхэмлэж, малчин өрхүүдэд өвөл, хаврыг өнтэй давахад нь дэмжлэг болгон өвс тэжээлийн тусламж үзүүлэх, сар шинээр өндөр настнуудад гарын бэлэг гардуулах зэрэг ажлуудыг жил бүр уламжлал болгон зохион байгуулж, орон нутгийн тогтвортой хөгжлийг дэмжих төсөл, хөтөлбөрүүдээ тууштай үргэлжлүүлж ажиллалаа.

Орон нутгийн хамтын ажиллагааны гэрээ



Орон нутагтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав
2017 оны 6-р сарын 22

2017 онд Өмнөговь аймагтай Хамтын ажиллагааны гэрээ байгуулж, аймаг, орон нутагтай харилцах харилцаа, хамтын ажиллагаагаа илүү өргөн түвшинд баталгаажууллаа. Энержи Ресурс компани нь орон нутагт уул уурхай, нийгмийн дэд бүтцийг цогцоор шийдэж, орон нутгийн боловсрол, ажил эрхлэлт, эрүүл мэнд, байгаль орчны чиглэлээр нийгмийн хариуцлагын цогц бодлоготой ажиллаж ирсэн. Тухайлбал, компани өнөөдрийн байдлаар 1,797 ажиллагсадтай бөгөөд үүний 50 орчим хувийг орон нутгийн иргэд бүрдүүлдэг. Мөн зөвхөн компанийн хөрөнгө оруулалтаар 2009 оноос хойш Цогтцэций суманд уурхайн цогцолбор дагасан эрчим хүч, орон сууц, сургууль цэцэрлэг гээд холбогдох бүхий л дэд бүтцийг барьж байгуулсан.

Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр

Уул уурхайн эрчимтэй хөгжилтэй зэрэгцэн уламжлалт мал аж ахуй эрхлэгч малчин өрхийн амьжиргааг сайжруулах, тэдний бизнес эрхлэлтийг дэмжих хүрээнд “Малчдын тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөр”-ийг 2012 оноос санаачлан хэрэгжүүлж ирсэн.

Өнгөрсөн хугацаанд Хас банктай хамтран уурхайн нөлөөллийн бүсийн малчин өрхүүдэд бичил зээл олгох хөтөлбөрийг эхлүүлж, Цогтцэций, Баян-Овоо, Ханбогд сумын нийт 15 малчин өрхөд хөнгөлөлттэй зээл олгон, өрхийн бизнест нь дэмжлэг үзүүлсэн. Малчдад зөвхөн зээл олгож санхүүгийн дэмжлэг үзүүлээд зогсохгүй тэднийг өрхийн бизнесээ өдөр тутам хөтлөн явуулах, мэдлэг, мэдээллээ сайжруулахад нь мэргэжлийн



Иргэдийн тогтвортой амьжиргааг дэмжих хөтөлбөрт хамрагдсан иргэн С.Зулын оёдлын цех

дэмжлэг туслалцаа үзүүлэх зорилгоор орон нутгийн “Амжилтын томъёо”, “Говийн хөгжлийн зуун” ТББ-уудтай хамтарч, бизнесийн зөвлөх үйлчилгээ, сургалт, семинаруудыг хийсээр ирсэн.

2017 онд уг төслийн хоёрдугаар үе шатыг эхлүүлж, цар хүрээг нь өргөжүүлэн, шилжин суурьшсан ажиллагсдын ар гэрийн гишүүдийг хамруулснаар тэдний жижиг дунд бизнесийг дэмжиж,

нийт 13 иргэнд 87 сая төгрөгийн хүүгүй зээл олголоо. Эдгээр иргэд 5-10 сая хүртэлх зээлийн санхүүжилтээ мал аж ахуй, газар тариалан, гоо сайхны худалдаа, нүдний эмнэлгийн тоног төхөөрөмж худалдаж авах, хоолны газрын тохижилт, пэйнт болл тоглоомын газар байгуулах, бууз, баншны цех, оёдлын цех ажиллуулах зэргээр бизнесээ өргөтгөх болон шинээр нээхэд зарцуулжээ.

Орон нутгийн сургуулийн багш, ажиллагсдын тогтвортой ажлын байрыг дэмжих хөтөлбөр

Энерги Ресурс компани 2013 онд Өмнөговь аймгийн ЗДТГ-тай хамтран Цогтцэций суманд “Мөрөөдөл” сургууль, цэцэрлэгийн цогцолбор байгуулж өгөөд зогсохгүй Улаанбаатар хотоос туршлагатай багш, ажиллагсдыг урьж ажиллуулах, англи хэл, математикийн гүнзгийрүүлсэн сургалт нэвтрүүлэх зэргээр боловсролын менежментийн цогц хөтөлбөр хэрэгжүүлж ирсэн. Энэхүү урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд орон нутагт ажиллахаар шилжин суурьшсан, чадварлаг багш ажиллагсдыг тогтвор суурьшилтай ажиллуулахад нь дэмжлэг болгох үүднээс Цогтцэций суман дахь “Цэций” хорооллын нийт 483 сая төгрөгийн үнэ бүхий 6 орон сууцыг олголоо. Энэ нь орон нутагт нэн ихээр дутагдалтай байдаг чадварлаг боловсон хүчин, чанартай боловсролыг дэмжихэд бодит хөрөнгө оруулалт болсон.

“Ойн зурвас” төсөл



Нийт 10 га газарт 86,000 мод бут, сөөг тарьж говь нутагт баянбүрд бий болгож байна



Мөрөөдөл цогцолборын багш, ажилтнуудад орон сууц гардуулав
2017 оны 5-р сарын 10

Цөлжилтийг бууруулах, өрхийн орлогыг нэмэгдүүлэх, газар тариалан эрхлэлтийг дэмжих урт хугацааны бодлогоор газар тариалангийн “Ойн зурвас” төслийг 2011 онд эхлүүлсэн. Энэхүү салхины хамгаалалтын зурвас нь одоогийн байдлаар 10 га талбайг эзлэх бөгөөд дунд нь 7 га газар тариалангийн талбай бий болгож, Цогтцэций сумын ЗДТГ-тай хамтран ажиллаж байна.

Төслийн гол зорилго нь сумын иргэд болон шилжин суурьшсан ажиллагсдын гэр бүлийн гишүүдийн газар тариалан эрхлэх идэвхи санаачилгыг дэмжих, туршлага, ур чадварыг нэмэгдүүлэх, нутгийн хөрсөнд ургуулсан эрүүл төмс, хүнсний ногоогоор өрхийн хэрэгцээгээ хангахад нь дэмжлэг үзүүлэх, цаашлаад

өрхийн бизнесийг дэмжиж, орлогыг нэмэгдүүлэх, орон нутгийн хүнсний ногооны зах зээлийн тодорхой хувийг хангахад туслалцаа үзүүлэх явдал юм.

Тайлант онд газрын хөрс боловсруулалт, үрслэг бойжуулах, хортон шавьжнаас хамгаалах, зэрлэг ургамал устгах сургалтууд зохион байгуулж, 30 гаруй иргэдийг хамруулав. Түүнчлэн тариалалтын

усжуулалтын системийг шинэчилж, харуул хамгаалалтын асуудлыг шийдвэрлэн мал, амьтан орохоос сэргийлсэн 1,300 метр хашааг шинэчлэн барьсан. 2017 онд ойн зурвасын 4 га талбайд 60 гаруй өрх ногоо тарьж, нийт 18 нэр төрлийн 13,8 тонн төмс, хүнсний ногоо хураан авчээ.

"Ухаа Худаг" наадам – 2017



Орон нутгийн олон авъяастнууд "Ухаа Худаг" наадамд тогтмол оролцдог

Энержи Ресурс компаниас орон нутгийн иргэдэд хүндэтгэл үзүүлэх, компанийн үйл ажиллагаагаа сурталчлан таниулах, соёлын өв, уламжлалт ёс заншлаа түгээн дэлгэрүүлэх зорилгоор "Ухаа Худаг" наадмыг жил бүр зохион байгуулдаг ба наадмын

цар хүрээ жилээс жилд өргөжиж, тус наадамд нутаг нутгийн хүчит бөхчүүд, алдарт уяачид, эрхийн мэргэн харваачид оролцдог болсон.

"Ухаа Худаг-2017" наадмыг Өмнөговь аймгийн зүүн бүсийн сумдыг хамруулан наймдугаар сард Цогтцэций суманд өргөн дэлгэр зохион байгууллаа. Наадамд хүчит 64 бөх, өсвөрийн 32 бөх барилдаж, дөрвөн насны хурдан морины уралдаан болж, халх сурын харваанд 70 гаруй эрхий мэргэн харваачид цэц мэргэнээ сорьсон. Мөн "Цэцийн жонон" морин хуурын хамтлаг, Ханхонгор сумын урлагийн сургуулийн сурагчид, аймгийн ХЖТ-ын уран бүтээлчид гээд нутгийн олон авъяастнууд оролцож, түүх, соёлын баялаг уламжлалтай говь нутгийнхаа өв соёлыг сурталчлан таниулав.

Уламжлал ёсоор наадамчин олны дунд үндэсний хувцсаараа гоёсон сайхан хосыг шалгаруулж, наадмын нээлт, хаалт, үдшийн цэнгүүнд Монгол Улсын урлагийн алдартнуудын төлөөлөл оролцож, баяр наадмыг чимж, наадамчин олныг баясган цэнгүүлсэн юм.

Монгол Ганжуур, Данжуурыг хөрвүүлэх үйлс

Энержи Ресурс компани нь соёлын биет болон биет бус өвийг хамгаалах, хадгалах бодлогын хүрээнд "Цогт цагийн хүрдэн" ТББ-ын хүсэлтийг хүлээн авч, 2013 оноос эхлэн Монгол Ганжуур, Данжуур их хөлгөн судрыг кирилл бичигт хөрвүүлэн бүтээж, олон нийтийн хүртээл болгох, өв соёлыг түгээн дэлгэрүүлэхэд хувь нэмрээ оруулан, ном судар бүтээх ариун үйлсэд хамтран ажиллаж байна.

Одоогийн байдлаар "Цогт цагийн хүрдэн" соёлын төвийнхөн их хөлгөн судрын хөрвүүлгийн эхний 311 ботийг хөрвүүлэн хэвлүүлжээ. Уламжлалт өв соёлыг сэргээх, түгээн дэлгэрүүлэх, орчин цагийн монгол



Ганжуур, Данжуурын төслийн хүрээнд эрдэмтдийн зөвлөл ажилладаг

хэлний үгийн санг баяжуулах үндэсний бахархлыг бий болгох гээд өндөр ач холбогдолтой энэхүү төслийг

компанийн зүгээс урт хугацаанд дэмжсээр ирсэн юм.

“Сайн хөрш”-ийн хамтын ажиллагаа

Сар шинийн баярыг угтан уламжлал ёсоор уурхайн удирдлагууд сумдын Ахмадын хороотой хамтран Цогтцэций, Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор сумдын 70-аас дээш насны 400 ахмадыг хүлээн авч, санал хүсэлтийг нь сонсон гарын бэлэг гардуулж хүндэтгэл үзүүлээ. Мөн говь нутгаар өвөлжилт хүндэрсэнтэй холбогдуулан Өмнөговь аймгийн Ханбогд, Баян-Овоо, Ханхонгор, Цогтцэций, Номгон сумдын 300 малчин болон сумдын өвсний фондод 8,000 боодол өвс, 1,650 уут хивэг, тэжээл хандивласан. Компанийн зүгээс жил бүрийн өвөл, хавар энэхүү тусламжийн ажлаа зохион байгуулж ирсэн уламжлалтай.



Сар шинийн баяраар ахмадуудад хүндэтгэл үзүүлж заншсан

Өвөлжилтийн хэрэгцээний нүүрсний дэмжлэг

“Сайн хөрш” хөтөлбөрийн хүрээнд орон нутгийн төрийн болон ТББ-ууд, оролцогч талуудтай тасралтгүй хамтын ажиллагаа хөгжүүлж ирсэн. Энэ хүрээнд 2009 оноос хойш жил бүр Өмнөговь аймгийн Даланзадгад болон Ханбогд, Ханхонгор, Баян-Овоо сумдад өвөлжилтийг өнтэй давахад зориулан эрчим хүчний нүүрс үнэ төлбөргүй нийлүүлж ирсэн. Тайлант онд Даланзадгадын дулааны цахилгаан станц болон Өмнөговийн сумдын өвөлжилтийн хэрэгцээнд нийт 470 орчим сая төгрөгийн өртөг бүхий 32 мянган тонн эрчим хүчний нүүрс нийлүүлсэн байна.



Сүүлийн 10 жил орон нутгийн эрчим хүчний нүүрсний хэрэгцээг тасралтгүй хангаж байна

АЖЛЫН БАЙР



ХҮНИЙ НӨӨЦИЙН БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь Монгол Улсын Хөдөлмөрийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу ажиллагсдыг хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагад тохирсон, ажлын байрны дарамтнаас ангид нөхцлөөр хангах, хөдөлмөрийн үр дүнд нь тохирсон цалин хөлс олгох, нийгмийн даатгалд даатгуулах зэрэг үндсэн заалтуудыг чандлан мөрдөхийн зэрэгцээ манай улсын нэгдэн орсон Олон Улсын Хөдөлмөрийн Байгууллагын конвенц болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад акт, хамтын гэрээ хэлэлцээрийг дагаж биелүүлдэг.

Ажиллагсад нь компанийн амжилтын гол хүчин зүйл учраас чадварлаг боловсон хүчин, хамт олныг бий болгох, тогтоон барих, сурган хөгжүүлэх нь манай компанийн хувьд чухал ач холбогдолтой байдаг. Энэ утгаараа компанийн зүгээс ажлын байрны эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлж, ажиллагсдынхаа нийгмийн асуудлыг шийдвэрлэх, шилжин суурьших нөхцлийг бүрдүүлэх, хувь хүний болон мэргэжлийн хувьд тасралтгүй өсөн дэвжих боломжийг бүрдүүлэхэд онцгой анхаарч, хүний нөөцийн бодлогодоо тусган ажиллаж байна.

Мөн насанд хүрээгүй хүүхдийн хөдөлмөр, албадан хөдөлмөрийн аливаа хэлбэрүүдийг үл тэвчих зарчим баримтлан холбогдох олон улсын конвенц, хууль дүрмүүдийг мөрдлөг болгон ирсэн.

АЖЛЫН БАЙР, ТЭГШ БОЛОМЖ



2017 онд шинээр 695 хүнийг ажлын байраар хангажээ

Тус компани нь хариуцлагатай уул уурхайн зарчмуудыг хэрэгжүүлэгчийн хувьд ажиллагсдын эрхийг дээдэлж, тэднийг ижил тэгш боломжоор хангадаг. Ажилтан, ажиллагсдыг сонгон шалгаруулахдаа ажил горилогсдын мэргэжил, ур чадварын түвшинг эн тэргүүнд харгалзан үзэхээс гадна орон нутгийн иргэдийг ажлын байраар хангах чиглэлд онцгой анхаарал хандуулж ирсэн.

2017 оны 12-р сарын байдлаар тус компани нийт 1,797 үндсэн ажиллагсадтай байсны 47 хувийг

орон нутгийн иргэд, тодруулбал Өмнөговь аймгийн Цогтцэций, Даланзадгад, Манлай, Баян-Овоо, Цогт-Овоо сумын иргэд зонхилон бүрдүүлж байна.


Компанийн хөдөлмөрийн дотоод журмын дагуу ажилтны нас, хүйс, шашин шүтлэг, улс төрийн үзэл баримтлал, оршин суугаа орон нутаг, харъяалал зэргээс үл хамаарсан цалин, хөлс олгож, тэгш хөгжих боломжийг хангадаг бөгөөд цалингийн зөрүү нь зөвхөн тухайн ажилтны боловсрол, ур чадварын түвшин, туршлага болон зэрэг, дэв зэргээс хамаардаг.

Тайлант онд нийт ажиллагсдын 13%-ийг эмэгтэй ажиллагсад бүрдүүлсэн бөгөөд тэдгээрийн 15% нь менежер болон удирдах түвшинд, 55% нь мэргэжлийн буюу техникийн түвшинд, 30% нь судлаач, инженер, геологич зэрэг мэргэжилтний түвшинд тус тус ажиллаж байна. Энэ нь дотоодын төдийгүй олон улс дахь уул уурхайн салбарын дунджаас дээгүүр үзүүлэлт бөгөөд менежер ба удирдах түвшинд эмэгтэйчүүдийн оролцооны хувь хэмжээг тогтмол өсөлттэй хадгалж ирлээ. Насны ангиллаар нь авч үзвэл нийт ажиллагсдын дийлэнхи буюу 64%-ийг 18-35 насныхан, 36%-ийг 36 болон түүнээс дээш насныхан бүрдүүлж байна.


Компанийн ажиллагсдын мэдээлэл (2015-2017)

	2015/12/31	2016/12/31	2017/12/31
1. Нийт ажиллагсдын тоо	1,797	1,442	1,797
2. Нийт эмэгтэй ажиллагсдын тоо	259	219	227
3. Удирдах түвшний эмэгтэй ажиллагсдын тоо	40	34	33
4. Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь	45%	63%	47%


Эмэгтэй ажиллагсдын эзлэх хувь (2017)




Ажиллагсдын насны ангилал (2017)



Орон нутгийн ажиллагсдын эзлэх хувь (2017)



Эмэгтэй ажиллагсдын албан тушаал (2017)



НИЙГМИЙН ХАЛАМЖ

Компанийн зүгээс ажиллагсдын цалин хангамж, урамшуулал болон нийгмийн халамжийн чиглэлээр тодорхой бодлого, журмыг хэрэгжүүлэн ажилладаг.

Тус компанийн санхүүгийн нөхцөл байдал, хувь хүний ажлын болон багийн гүйцэтгэлээс хамааран ажиллагсдад гүйцэтгэлийн урамшууллыг тооцон олгодог.

Нийт ажилтнууддаа орон сууц худалдан авахад нь банкны хөнгөлөлттэй зээл олгох, даатгал, эрүүл мэндийн үзлэгт хамруулах, гэр бүлээрээ нүүн суурьшиж буй ажилтнуудын гэр бүлийг ажилд ороход нь дэмжлэг үзүүлэх, мөн ажиллагсдын хүүхдүүдийн сургууль цэцэрлэгийн асуудлыг шийдэхэд нь тусламж, дэмжлэг үзүүлэх зэргээр ажиллагсдын нийгмийн асуудалд нэн тэргүүнд анхаарал хандуулсаар ирсэн.

Ажиллагсдыг суурьшуулах бодлогын хүрээнд Цогтцэций суманд барьж байгуулсан орон сууцны “Цэций” хороололд одоогийн байдлаар 600 орчим ажиллагсад гэр бүлийнхээ хамтаар тохь тухтай



“Цэций” хороололд 600 гаруй ажилтан гэр бүлийн хамтаар амьдарч байна

амьдарч байна. Тайлант онд компанийн хэмжээнд нийт ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэг болон дотоодын эрүүл мэндийн даатгалд бүрэн хамруулсан.

ШИЛЖИЛТ ХӨДӨЛГӨӨН

2017 онд шинээр 695 хүнийг ажлын байраар хангасан бөгөөд ингэснээр ажиллагсдын шилжилт хөдөлгөөний жилийн үзүүлэлт 25%-тай байна. Компанийн зүгээс ажиллагсдынхаа нийгмийн асуудалд анхаарч, хөнгөлөлт, хангамжийн бодлогоо хэвээр үргэлжлүүлэн, гэр бүлээр нь орон нутагт шилжүүлэн суурьшуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэн

ажилласан. 2013 оноос хойш нийт 750 ажилтан гэр бүлийн хамтаар орон нутагт шилжин суурьшсан байна.

Тайлант онд орон сууцны “Цэций” хороололд 27 ажилтныг, “Уурхайчин” хороололд 57 ажилтныг гэр бүлийн хамт тус тус суурьшуулсан.

Мөн тогтвортой ажиллах гэрээний үүргээ



2017 онд Цэций хороололд 26 ажилтан гэр бүлийн хамт шилжин суурьшжээ

биелүүлсэн нэг ажилтанд орон сууц, 95 ажилтанд хашаа газрын өмчлөлийг үнэ төлбөргүй шилжүүлж өгсөн. Ажилтнуудыг суурьшуулах болон орон сууц, хашаа газрын өмчлөлийг шилжүүлэхтэй холбоотой зардалд нийт 683 сая төгрөг зарцуулсан байна.

Өнөөдрийн байдлаар компанийн нийт ажилтнуудын 65% нь тогтвор суурьшилтайгаар 5 болон түүнээс дээш жил ажиллаж байгаа нь компанийн зүгээс хүний нөөцийн бодлогодоо онцгойлон анхаарч, ажилтнуудаа ижил, тэгш боломжоор хангаж ирсний үр дүн юм.

СУРГАЛТ ХӨГЖИЛ

Компани байгуулагдсан цагаас эхлэн мэргэжилгүй иргэдийг уул уурхайн чиглэлээр мэргэшүүлж, ажлын байраар хангах, ажилтнуудынхаа мэргэжлийн ур чадварыг сайжруулах, хувь хүний ерөнхий ур чадварыг нэмэгдүүлэх, байгууллагын соёлыг төлөвшүүлэх сургалтуудыг тогтмол зохион байгуулсаар ирсэн. Тайлант онд ерөнхий ур чадварын болон нарийн мэргэжлийн нийт 66 төрлийн сургалтанд давхардсан тоогоор 1,634 ажиллагсдыг хамруулсан нь өнгөрөгч оныхоос даруй 300 хувиар өссөн үзүүлэлт юм.

Тодруулбал 34,013 хүн/цаг сургалт явагдсан бөгөөд нэг ажилтанд дунджаар 21 цагийн сургалт ногдож байна. Түүнчлэн тайлант онд Ухаа Худаг уурхайн дэргэдэх Сургалтын төв өргөжин, техник хэрэгслээ шинэчилсэн. Уг төвд хүнд машин механизмын оператор, засварчин, цахилгаанчин



Ухаа Худаг уурхайн симуляторын төв

зэрэг мэргэжлээр бэлтгэхээс гадна ажиллагсад болон уурхайд ирсэн зочдод Хөдөлмөрийн аюулгүй байдлын сургалт, зааварчилгаа өгдөг.

Сургалтын мэдээлэл (2015- 2017)

	2015	2016	2017
1. Нарийн мэргэжлийн сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо	140	319	1,238
2. Ерөнхий ур чадварын сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо	5	10	396
3. Нийт сургалтанд хамрагдсан ажиллагсдын тоо	145	329	1,634

БАЙГАЛЬ ОРЧИН



БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Энержи Ресурс компани нь үйл ажиллагааныхаа бүхий л үе шатанд ажиллагсдын аюулгүй байдал, эрүүл мэндэд учирч болох сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд нэн тэргүүний ач холбогдол өгч, байгаль орчны чиглэлийн холбогдох бүхий л хууль, стандартуудыг мөрдөж ажилладаг.

Энержи Ресурс компани нь Байгаль орчин, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй (БОХАБЭА)-н хүрээнд олон улсын ISO 14001:2004 “Байгаль орчны удирдлагын тогтолцоо” болон OHSAS 18001:2007 “Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн удирдлагын тогтолцоо” стандартын шаардлагатай нийцүүлсэн, нэгдсэн удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажиллаж байна. Энэхүү нэгдсэн удирдлагын тогтолцоо нь БОХАБЭА-н бодлого, зорилго, зорилт, шаардлага болон тэдгээрт хүрэх арга замыг тодорхойлсон цогц систем тул компаниас хэрэгжүүлж буй бүхий л төсөл, үйл ажиллагаанд хүрч мөрдөгддөг.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Монгол Улсын хууль тогтоомж болон олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын шаардлагад нийцүүлсэн байгаль орчны нарийвчилсан үнэлгээг Ухаа Худаг төсөл эхлэхээс өмнө хийж гүйцэтгэн, төслөөс үүдэлтэй байгаль орчинд учирч болохуйц сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх зорилготой менежментийн төлөвлөгөө боловсруулсан. Энэ хүрээнд Ухаа Худаг уурхайн үйл ажиллагаанд хог хаягдал, ус, тоосжилт, хөрсний элэгдэл, эвдрэл, нөхөн сэргээлт зэрэг чиглэлүүдээр төрөлжсөн менежментийн төлөвлөгөөнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж ирсэн.

Мөн оролцогч талуудын чухал төлөөлөл болох

орон нутгийн иргэдийн байгаль орчны мэдлэг боловсролыг дээшлүүлэх зорилгоор сургуулийн сурагчид, нутгийн малчид, иргэдэд ойжуулалт, зүлэгжүүлэлт, хог хаягдлын менежмент, байгалийн нөөцийн зохистой ашиглалтын талаар сургалт явуулж, орчны хяналт шинжилгээнд нутгийн иргэдийг оролцуулж, тэднээр хөндлөнгийн хяналт хийлгэдэг.

Тайлант онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд Ухаа Худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцтэй байдлыг 94% буюу хангалттай хэрэгжүүлдэг гэж үнэлсэн.

ОНЦЛОХ АЖЛУУД:

- Ухаа Худаг төслийн талбайд мод сөөг тарьж ургуулах ажлын хүрээнд нийт 5,695 ш мод сөөгний суулгац тарьсан. Мөн мод үржүүлгийн талбайд сухайны мөчир 2,000 ш, улиасны мөчир 300 ш, жигдний үр 1,000 ш, хайлаасны үр 1 кг, харганы үр 0.5 кг, загийн үр 200 ш бортогонд, буйлсны үр 400 ш бортогонд тус тус тарьж бойжуулав.
- Биологийн төрөл зүйлийг дүйцүүлэн хамгаалах судалгаа, тооцооллыг мэргэжлийн байгууллагаар хийж гүйцэтгүүлсэн бөгөөд дүйцүүлэн хамгаалал хийх байршлын талаар орон нутгийн засаг захиргааны байгууллагуудаас санал авч тодорхойлсон.
- Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн дагуу байгаль орчны төлөвлөгөөт аудитыг мэргэжлийн байгууллагаар хийлгэсэн бөгөөд Ухаа Худаг төслийн байгаль орчны хууль эрх зүйн нийцтэй байдлыг 94% буюу хангалттай хэрэгжүүлдэг гэж үнэлсэн.
- Төслийн үйл ажиллагаанаас үүсдэг тоосжилтын нэг эх үүсвэр болох Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн хаягдлын хатаж хуурайшсан хэсгийн 20%-ийг хөрсөөр хучиж тоосжилтоос урьдчилан сэргийлсэн.
- Ургамалжуулсан шимт хөрсний овоолгын 1.4 га талбайд усалгаа арчилгаа, нөхөн тарилт хийж, усалгаа арчилгааг тогтмол явуулсан. Дээрх ажлын үр дүнд ургамалжуулсан талбайн бүрхэц 90% -с дээш болсон.
- Цэций хайрхан уулын туруутан амьтад болох аргаль, янгирт зориулж өвс, мөс, хужир тавьж өгөх ажлыг сумын байгаль хамгаалагч нартай хамтран зохион байгуулсан.

Усны зохистой хэрэглээ

Энержи Ресурс компани нь олон улсын жишигт нийцсэн үйл ажиллагаа явуулдаг үндэсний уул уурхайн компани гэдэг утгаараа хариуцлагатай уул уурхай, тэр дундаа усны менежментийн асуудалд онцгой анхаарал хандуулдаг. Ялангуяа цэвэр усаар хомс говь нутгийн байгалийн онцлогийг дээд зэргээр

харгалзан үзэж, усны зохистой хэрэглээг чухалчилдаг.

Ухаа Худаг уурхайн цогцолбор нь үйлдвэрлэлийн болон ахуйн хэрэглээний ус хангамжийн ухаалаг, дэвшилтэт системийг нэвтрүүлэн ажилласнаар уурхайн нийт төслүүдийн усны хэрэгцээг хангадаг. Говь нутгийн ус нь эрдэсжилт, хатуулаг ихтэй учраас

ундны усанд тогтмол хэрэглэх нь тохиромжгүй байдаг. Иймд Энержи Ресурс компани ундны усыг цэнгэгжүүлж, Цогтцэций сумын хүн ам болон уурхайн ажиллагсдын хотхоныг эрүүл ахуйн шаардлагад нийцсэн, ундны цэвэржүүлсэн усаар хангаж байна.

Мөн Нүүрс баяжуулах үйлдвэрийн дэргэд Хаягдлыг усгүйжүүлэх үйлдвэрийг байгуулж, үйлдвэрээс гарч байгаа нүүрсний лаг хаягдлаас усыг шавхан, дахин ашиглаж, үйлдвэрийн усны дахин ашиглалтыг 98 хувьд хүргэсэн. Түүнчлэн цахилгаан

станцдаа агаарын хөргөлтийн технологи тусгайлан суурилуулсан учраас Монгол дахь бусад цахилгаан станцуудтай харьцуулахад усыг 4-5 дахин хэмнэдэг.

Ухаа Худаг уурхайн усны чанарын лабораторийн үйл ажиллагаа, техник технологи, мэргэжилтнүүдийн чадавхи нь холбогдох шаардлагуудыг бүрэн хангасан учир Монгол Улсын стандарт хэмжил зүйн газраас тус лабораторид итгэмжлэл олгосноор дотоодын хяналтыг өндөр түвшинд, стандартын шаардлага хангасан байдлаар явуулж байна.

Нөхөн сэргээлтийн туршилтын талбай

Байгаль орчны нөхөн сэргээлтийн туршилтын талбайд олон төрлийн мод, бут, сөөг, нутгийн болон олон наст ургамлыг туршилтын журмаар ургуулан, тухайн бүс нутагт хамгийн сайн зохицсон ургамлыг сонгон шалгаруулж, улмаар биологийн нөхөн сэргээлт болон орчны тохижилтод ашигладаг.

Тайлант хугацаанд туршилтын талбайд сухайны мөчир 2,000 ширхэгийг бэлтгэж, жигд, харгана, шар хуайсыг тарьж ургуулсан бөгөөд өмнөх жилүүдэд тарьсан, бойжуулгын хэсэгт ургаж байгаа хайлаас, сухай, харганы өсөлт хөгжлийг хэвийн явуулах зорилгоор графикийн дагуу усалгаа арчилгааг тогтмол хийсэн байна. Уг талбайгаас бэлтгэсэн 3,025

ширхэг тарьц суулгацыг элэгдэл эвдрэлд орсон талбайг ургамалжуулах, төслийн талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор төлөвлөсөн цэгүүдэд тарьж ургууллаа. Мөн мод үржүүлгийн талбайгаас ирэх жилийн тарилтанд ашиглах буйлс, жигд, харганы үрийг түүж бэлтгэсэн.

Мөн төслийн үйл ажиллагаанаас үүсдэг тоосжилтын нэг эх үүсвэр болох Нүүрс баяжуулах үйлдвэрийн хаягдлын далангийн хаягдлын хатаж хуурайшсан хэсгийн 20%-ийг хөрсөөр хучих ажил гүйцэтгэж үүсэх тоосжилтоос урьдчилан сэргийлсэн бөгөөд байгаль орчны нэгж ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан.

Шимт хөрсний овоолгын ургамалжуулалт



Шимт хөрсний талбайд буурцагт ургамал тарьж, тогтмол арчилдаг

Шимт хөрсний овоолгын ургамалжуулалт бүхий 1.4 га талбайд нөхөн тарилт хийж, усалгаа арчилгааг тогтмол явуулсан. Нөхөн тарилтанд говь хээрийн хуурай уур амьсгалтай нөхцөлд ургах чадвартай буурцагт ургамлын төрөл зүйл болох шар царгас болон хүцэнгийн холимог үрийг ашигласан байна.

Буурцагт ургамал нь хөрсний шим тэжээлийн элемент, азотыг баяжуулдаг тул шимт хөрсний овоолго дээр тарихад хамгийн тохиромжтой байдаг.

Мөн 20 кг орчим нутгийн холимог ургамлын үрээр нөхөн тарилт хийж, усалгаа арчилгааг тогтмол явуулсан бөгөөд дээрх ажлын үр дүнд ургамалжуулсан талбайн бүрхэц 2017 онд 90%-иас дээш болсон.

Ногоон орчин

Төслийн талбайд мод сөөг тарьж ургуулах ажлын хүрээнд хаврын тарилтаар 2,945 ш мод сөөгний тарьц суулгац, намрын мод тарилтын үеэр 2,750 ш суулгац тус тус бэлтгэж нийт 5,695 ш мод сөөгний суулгацыг хатуу хучилттай зам дагуу ба “Цэций” хорооллын ногоон байгууламжинд тарьсан. Мөн мод үржүүлгийн талбайд сухайны мөчир 2,000 ш, улиасны мөчир 300 ш, жигдний үр 1,000 ш, хайлаасны үр 1 кг, харганы үр 0.5 кг, загийн үр 200 ш бортогонд, буйлсны үр 400

ш бортогонд тус тус тарьж бойжуулав. Зам дагуу тарьсан моддыг хамгаалалтын хашаатай болгож, усалгааны систем суурилуулж усалгаа арчилгааг тогтмол явуулсны дүнд моддын ургалт, өсөлт сайн байна.

Үүнээс гадна Цогтцэций сумын ЗДТГ-ын хүсэлтээр 1,800 ш хайлаасны суулгац хаврын мод тарилтын үед бэлтгэн өгч ногоон байгууламж бий болгох ажилд дэмжлэг үзүүлэв.

Байгаль орчны хяналт, үнэлгээнд иргэдийн оролцоо



Тоосны хэмжилтэнд оролцож, хяналт тавьж буй орон нутгийн иргэд

Орон нутгийн иргэдэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулах, байгаль орчны хээрийн хэмжилтэнд иргэдийг оролцуулах, хэмжилтийн бодитой мэдээллийг иргэдэд өгөх

зорилготой сургалт, танилцуулгын ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн. Энэ ажлын хүрээнд иргэд компанийн байгаль орчны бодлого болон байгаль хамгаалах ажлын талаарх мэдээллийг тогтмол авч, малчдын худгаас усны дээж авч шинжилгээ хийх, усны түвшин хэмжих, орчны тоосжилтийн хэмжилт хийх, дуу шуугианы хэмжилт хийх ажилд биечлэн оролцож байна.

2017 онд Цогтцэций сумын төрийн байгууллагын ажилтнууд, малчид, “Цэций” хорооллын оршин суугчдын төлөөлөл зэрэг иргэд, олон нийтэд байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг танилцуулж, худгийн усны болон тоосны хэмжилтийг газар дээр нь хийж үзүүлэн, хэмжилтийн бодит үр дүнг танилцууллаа. Ийнхүү хамтын оролцоотой мониторингийн ажлыг тогтмолжуулснаар компани болон орон нутгийн иргэд, бусад оролцогч талуудын харилцан итгэлцэл нэмэгдэх, бүх оролцогч талууд нэгдсэн ойлголтонд хүрэх чухал ач холбогдолтой юм.

Уст цэгүүдийн цэвэрлэгээ

Ухаа Худаг төслийн ойролцоо нутагт байрлах уст цэгүүдийн хатуу хог хаягдлыг цэвэрлэх ажлыг тогтмол зохион байгуулж ирсэн бөгөөд тайлант онд “Хээрийн булаг”, “Жирмийн булаг”, “Булаг” нэртэй газруудын ойр орчмын 1.2 м³ орчим хатуу хог хаягдлыг цэвэрлэж, сумын нэгдсэн хог хаягдлын цэгт тээвэрлэн хүргэсэн.

Компанийн зүгээс Цогтцэций сумын Цагаан-



Малчдын гар худаг, уст цэгүүдийг тогтмол цэвэрлэдэг

Овоо багийн нутаг дахь “Наймантын хөндий”-д малчдын ахуйн болон мал усалгааны хэрэгцээнд зориулсан хоёр худаг шинээр гарган тоногдсон билээ. Эдгээр худгууд нь ховоо татах зэрэг биеийн хүчний ажиллагаа шаардахгүй, цорго нээснээр ажилладаг хялбар шийдэлтэй тул малчдын өдөр

тутмын ажлыг хөнгөвчилдөг давуу талтай.

Өнгөрсөн жил зуншлага тааруу байсантай холбогдуулан малчид болон сумдын удирдлагуудын хүсэлтээр дээрхи худгуудыг нээж, ойролцоо нутагладаг малчдад хүлээлгэн өгсөн.

Зэрлэг амьтдыг хамгаалах ажиллагаа



Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөт ажлын хүрээнд зэрлэг амьтдыг хамгаалах биотехникийн арга хэмжээ хэрэгжүүлэх зорилгоор “Цэций хайрхан” ууланд өвс тэжээл, мөс тавих арга хэмжээг жил бүр зохион байгуулсаар ирсэн.

2017 онд сумын байгаль хамгаалагчидтай хамтран зэрлэг амьтдад зориулж 140 кг байгалийн хужир болон давс, өвс тавьж өгсөн байна.

Байгаль орчны ажилтнууд өлдөж харангадсан янгирыг усалж буй нь

Зэрлэг амьтдыг ундаалах уст цэг

Өмнөговь аймгийн Ханбогд суманд өвлийн улиралд зэрлэг ан амьтдыг өлдөж, харангадах аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор уст цэгийг байгуулсан байна.

Энержи Ресурс компани болон тус сумын “Говийн бага дархан цаазат газар”-ын ажилтнууд, байгаль орчны байцаагчтай хамтран Цагаанхадны ойролцоох засмал замын зүүн талын уулын энгэрт цөөрмийн нүх гаргаж бэлдэн, усаар дүүргэсэн.

Уг газрын ойр орчимд зэрлэг ан амьтад цангаагаа тайлахуйц усны нөөц огт байдаггүй юм байна. Компанийн ажиллагсад хиймэл уст цэг дээр тогтмол очиж зориудаар ус хийж бэлдсэнээр уг цооногноос хулан, хар сүүлт, зээр, бор гөрөөс гэх мэт амьтад ундаалж, өлдөж харангадахын аюулгүй болжээ.



Зэрлэг амьтад ус уух боломжтой уст цэг байгуулав

Сургалт

2017 онд компанийн үндсэн ба гэрээт компанийн ажилтан ажиллагсдад байгаль орчны дотоод журмын талаар мэдээлэл өгөх, тэдний байгаль орчинд үзүүлэх зөв хандлагыг төлөвшүүлэх зорилготой байгаль орчны ерөнхий зааварчилгаанд 949 ажиллагсад буюу 949 хүн/цаг болон давтан зааварчилгаанд нийт 1,428 буюу 1,428 хүн/цаг ажилтан хамрагджээ.

Байгаль орчны ерөнхий ба давтан зааварчилгаанд компанийн байгаль орчны бодлого,

Хог хаягдлын менежмент ба бүртгэл

Ухаа Худаг төслийн үйл ажиллагааны явцад үүсэх үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээг тодорхойлох, хаягдлыг дахин боловсруулах, ангилах, хог үүсэлтийн хэмжээг хянаж бууруулах зорилгоор хог хаягдлын нэгдсэн бүртгэлийг үүсгэж, сар бүрээр хог хаягдлын мэдээнд анализ хийж байна. Энэхүү бүртгэлийг гаргаснаар хогийн цэгийн төлөвлөлт болон хог хаягдлын менежментийг сайжруулан төлөвлөхөд

Хог хаягдлын дахин ашиглалт

Ухаа Худаг уурхайд хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхдээ “3R+R” системийг ашигладаг. Тухайлбал, ангилан ялгасан хог хаягдлыг дахин ашиглаж бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг дахиврын цехийг дэргэдээ ажиллуулж, блок, хашаа, сандал, хогийн сав зэрэг олон нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг. Тайлант онд уг цехэд хаягдал ашиглан гэр ахуй, барилга, тохижилтонд ашиглагдах зургаан нэр төрлийн 70 гаруй бүтээгдэхүүнийг үйлдвэрлэн зах зээлд нийлүүлжээ.

Мөн сумын айл өрхүүдийн хог хаягдлыг ангилан ялгадаг болгох зорилгоор “Ногоон бийр” ТББ-ын санаачлагыг дэмжин ажиллаж, хаягдлаар хийсэн 50 поошигийг хогийн савны зориулалтаар хандивласан. Уг хогийн савнуудыг “Өгөөмөр” багийн хэрэгжүүлсэн “Жишиг гудамж” төсөлд хамрагдаж буй айл өрхүүд болон “Сийрст” багийн засаг даргад хүлээлгэн өгснөөр хог хаягдлаа ангилан ялгах туршилтыг эхлүүлэхээр болоод байна.

Аюултай хог хаягдлыг Монгол Улсын холбогдох

дотоод журам, хог хаягдлын сөрөг нөлөө, ангилан ялгах ач холбогдол, хөрсний бохирдол, элэгдэл эвдрэл, түүнээс сэргийлэх, хамгаалах арга хэмжээ болон орчны эрүүл ахуй, байгалийн нөөцийн зүй зохистой хэрэглээ гэсэн сэдвүүд хамаардаг.

Мөн Хог хаягдлын удирдлага, зохицуулалтын журам, Химийн бодисын удирдлага зохицуулалтын журмаар 56 хүн/цагийн сургалт орсон байна.

үр дүнтэй.

2017 онд нийт үүссэн хатуу хог хаягдлын 18% нь аюултай хаягдал байсан бол ахуйн хаягдал 42%, дахин ашиглагдах болон дахин боловсруулагдах хаягдал 40%-ийг эзэлж байсан. Аюулгүй хог хаягдлын дахин боловсруулалтын хэмжээ өмнөх онд 14% байсан бол тайлант онд 27% болж нэмэгджээ.



Хог хаягдлаар хийсэн уг сандалнуудыг сумын гудамж талбайд байршуулсан

хууль тогтоомж, журам стандартуудад бүрэн нийцсэн байдлаар устгалд оруулах буюу тусгай хүлээн авах цэгүүдэд хүргүүлдэг.

ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ, ЭРҮҮЛ АХУЙ



БОДЛОГО, БАРИМТЛАХ ЗАРЧИМ

Уул уурхайн салбарын хувьд хөдөлмөрийн аюулгүй байдал (ХАБ) нэн чухал асуудалд тооцогддог. Энэ ч утгаараа ажиллагсдынхаа аюулгүй байдал, эрүүл мэндийн асуудлыг чухалчлан үзэж, эрүүл аюулгүй ажлын орчин бий болгох нь Энержи Ресурс компанийн эрхэм зорилго байдаг. Нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлан, нийт ажиллагсдаа эрүүл, аюулгүй орчинд ажиллуулахаас гадна, өөрийн үйл ажиллагааны хүрээнд оролцогч бүх талуудын аюулгүй байдлыг олон улсын стандарт, жишигт нийцүүлэн хангахыг эрмэлздэг.

Энержи Ресурс компани нь Ухаа Худаг уурхайн үйлдвэрлэлийн бүхий л үе шатанд ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон олон нийт, орон нутгийн иргэдийн эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны шаардлагад нэн тэргүүний ач холбогдол өгч “Аюулгүй эхэлж, аюулгүй дуусгая” уриаг эрхэмлэн ажиллаж ирсэн.

ҮЙЛ АЖИЛЛАГАА

Ухаа Худаг төслийн хүрээнд олон улсын ‘ISO 14001:2015 Байгаль орчны удирдлагын тогтолцоо’ болон ‘OHSAS 18001:2008 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ерөнхий шаардлага удирдлагын тогтолцоо’ стандартуудын шаардлагын дагуу БОХАБЭА удирдлагын тогтолцоог нэвтрүүлэн ажилладаг. Тайлант онд дээрх стандартуудын хүрээнд дагаж мөрдөх журам, баримт бичгүүдэд дахин сайжруулалт хийн, нийт 15 төрлийн үндсэн журмуудыг дахин шинэчлэн боловсруулж, батлууллаа.

2017 онд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгч болон тэдгээрийн туслан гүйцэтгэгчдийн ажиллагсад 5.6 сая хүн цаг ажилласан тоон үзүүлэлттэй харьцуулахад Хөдөлмөрийн чадвар түр алдалтын давтамжийн үзүүлэлт (ХЧТАД) 0.45, мөн нийт гэмтлийн давтамж 5.49 байлаа. Компанийн хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд “Ослыг тэглэх алсын хараа” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд энэ нь ХЧТА-ийн давтамжийн үзүүлэлтээр гүйцэтгэл шалгуур үзүүлэлт болох 0.5 –аас 10% буурсан байна.

ОНЦЛОХ АЖЛУУД:

- Нийт 36 ажлын байранд давхардсан тоогоор 432 удаагийн үзлэг, хяналт хийн 988 үл тохирол ирүүлж, 902-ыг нь залруулснаар гүйцэтгэлийн биелэлт 91% байсан.
- МХЕГ, Өмнөговь аймгийн МХГ-ын хамтарсан хяналт шалгалт хөдөлмөрийн эрүүл ахуйн хяналтын хуудсаар шалгахад бага эрсдэлтэй буюу 83.5 хувийн үнэлгээ авсан. Мөн МХЕГ-ын хөдөлмөрийн нөхцлийн хэмжилтийн төвөөр ажлын байруудад хөдөлмөрийн нөхцлийн үнэлгээ хийлгэж, дүгнэлт гаргуулсан.
- Үйл ажиллагааны явцад ХАБЭА-н нөхцөл байдлыг сайжруулах зорилгоор Ухаа Худаг уурхайн ажиллагсад болон менежерүүдэд зориулсан ХАБ-ын манлайллын хөтөлбөр болох 5A, 5M, SMART.TL хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж, сар бүр дүгнэв.
- Компанийн ажилтнуудаас ХАБ-ын соёлын судалгаа авч, үр дүнг нэгтгэн сар тутмын төлөвлөгөөндөө тусган ажилласан.
- Олон улсын “ISO9001:2015 Чанарын менежментийн тогтолцооны стандарт” нэвтрүүлэх ажлыг Монголын Менежментийн Холбоотой хамтран эхлүүлээ.

ХАБ-ын гол үзүүлэлтүүд (2015-2017)

Үзүүлэлт	2015	2016	2017
Нийт ажилласан хүн/цаг	3,330,938	2,971,720	6,623,801
Эндэгдэл	0	0	1
Нийт гэмтлийн давтамж	2.7	4.37	5.13
ХЧТАД	0.6	0.34	0.45
Хууль, журамд нийцэж ажилласан байдал	87.2%	88.7%	82.6 %
ХАБ-ын сургалт, зааварчилгаа	5,202	5,629	9,469

СУРГАЛТ

Компанийн хэмжээнд хүлээсэн үүрэг хариуцлагын хүрээнд “Ослын давтамжийг тэглэх” зорилтыг дэвшүүлэн ажиллаж байгаа бөгөөд ХЧТАД-ийн тоон үзүүлэлтээр тооцож үзвэл тайлант онд энэхүү гүйцэтгэлийн дүн сайн гарсан.

Энэхүү гүйцэтгэл нь ХАБЭА-н удирдлагын тогтолцооны олон улсын ангиллын хэрэгжилт дээр

тулгуурласан байдаг.

Тайлант хугацаанд нийт ажиллагсад, гэрээт гүйцэтгэгчид болон зочид гэх мэт нийт 9,469 хүнд энэ чиглэлийн тусгай материал танилцуулах сургалтыг хүргэж, үүнд нийт 35,986.2 хүн/цаг зарцуулсан байна.

ХЯНАЛТ, ҮЗЛЭГ

ХАБ-ын хүрээнд ажлын байрны эрсдлийн үнэлгээ хийх, хөдөлмөрийн нөхцлийг тодорхойлох, нийт ажиллагсад ХАБЭА-н сургалт зохион байгуулах, ажлын байрны үзлэг тогтмол хийх, зөрчлийг арилгуулах, ослын судалгаа хийх гэх мэт ажлууд компанийн хэмжээнд тогтмол явагддаг.

2017 онд ажлын байрны аюулгүйн үзлэгийг нийт 120 удаа зохион байгуулж, бүх илэрсэн аюул болон үл тохирлуудын шалтгааныг судалж, дутагдал зөрчлийг

арилгахад шаардлагатай бүхий л арга хэмжээг авч ажилласан. Ажилтнууд 4,606 аюулыг мэдээлэх хуудас ирүүлснээс 3,714-ыг нь арилгасан бөгөөд мэдэгдэх хуудсаар мэдээлсэн аюулын 81 хувийг арилгасан үзүүлэлттэй байна.

Түүнчлэн ажиллагсад зориулсан ХАБЭА, аюулгүй ажиллагаа, осол, эрсдлийн менежмент, анхны тусламжийн сургалт, зааварчилгаанууд тогтмол хийгдэж байна.

ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ БОЛОН АВРАХ АЖИЛЛАГАА

Тайлант онд нийт ажиллагсад зориулсан эрүүл мэндийн хяналтын давтан үзлэгт 1,395 хүнийг хамруулж, 999 хүнд эрүүл мэндийн зөвлөмж өгсөн. Нүүрс тээврийн замд хяналтын үзлэгийг давхардсан тоогоор 2,756 ажилтанд хийж эмчийн зөвлөгөө, эмийн болон анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн.

Аврах ажиллагааны хүрээнд нийт 19 барилга

байгууламжид давхардсан тоогоор 389 удаа галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг шалгалт хийж 778 зөрчил илрүүлэн зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулсан. Гамшгаас хамгаалах болон аюулын үед хэрэгжүүлэх 2018 оны төлөвлөгөө боловсруулан холбогдох төрийн байгууллагаар батлуулан ажиллаж байна.

ТОВЧ ДҮГНЭЛТ



Энержи Ресурс компани нь одоогоор Монгол Улсын хэмжээнд нүүрсийг дотооддоо баяжуулж, нэмүү өртөг шингээн экспортлож буй цорын ганц компани бөгөөд 2017 онд коксжих нүүрсний зах зээлийн сэргэлтийг хурдтай ашиглаж, экспортын хэмжээгээ өсгөж, үйл ажиллагаагаа идэвхжүүлэн өндөр өсөлт үзүүлэн ажилласан.

Ингэснээр 2017 онд улсын төсөвт татвар шимтгэл хэлбэрээр 87 тэрбум төгрөг төвлөрүүлж, 3,000 орчим хүнийг шууд болон шууд бус ажлын байраар ханган ажилласан төдийгүй дотооддоо нэмүү өртөг шингээн баяжуулсан коксжих нүүрсэн бүтээгдэхүүнийг экспортлосноор 476 сая ам.доллар буюу 1.2 их наяд орчим төгрөгийн экспортын орлогыг улсын эдийн засагт оруулсан байна. Мөн орон нутгийг хөгжүүлэх төсөл, хөтөлбөрүүдээ тогтвортой үргэлжлүүлж, орон нутагт нийт 4.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт хийжээ.

Компанийн зүгээс ажиллагсдын, тэр дундаа орон нутгийн болон шилжин суурьшсан ажиллагсдын ажлын байрыг аль болох хадгалах, тэдний нийгмийн баталгааг хангах тал дээр анхаарч, өөрсдөөс шалтгаалах бүхий л арга хэмжээг шат дараатай авч хэрэгжүүлж байна.

Монгол Улсын Засгийн газар, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим хамтран ТОП-100 аж ахуйн нэгжийг эрэмбэлэхэд Энержи Ресурс компани 2017 оны Монгол Улсын ТОП 5 аж ахуйн нэгжийн нэгээр шалгарсан нь тус компанийн үйл ажиллагааг бодитоор үнэлж, амжилт, ололтыг бататгасан үйл явдал боллоо.

Энержи Ресурс компани цаашид оролцогч талуудтай хамтын ажиллагааг үргэлжлүүлэх, бататгах замаар орон нутаг төдийгүй улс орны тогтвортой хөгжил, эдийн засгийн өсөлтөнд бодит хувь нэмрээ оруулах, улмаар олон улсын зах зээлд Монголын брэнд болсон нүүрс, нүүрсэн бүтээгдэхүүн борлуулах дэлхийн түвшний үйлдвэрлэгч компани байх зорилтоо үргэлжлүүлэн ажиллаж байна.

ЭНЕРЖИ РЕСУРС КОМПАНИЙН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ (2017)

ЭНЕРЖИ
РЕСУРС ХХКНИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ
/2017 ОНД/

1

ТАТВАР ТӨЛӨЛТ



ХУДАЛДАН АВАЛТ



АЖЛЫН БАЙР



ЭКСПОРТЫН ОРЛОГО

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ҮР ӨГӨӨЖ
/2017 ОНД/


2

АЖЛЫН БАЙР



СУРГАЛТ

ДОТООДДОО СУРГАЖ БЭЛТГЭСЭН БОЛОВСОН ХҮЧИН



ОРОН НУТГИЙН ХАМТЫН АЖИЛЛАГАА
/2017 ОНД/

3

ИРГЭДИЙН ТОГТВОРТОЙ АМЬЖИРГААГ
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР

13 ӨРХИЙН
ЖИЖИГ ДУНД БИЗНЕС
₮87 сая
ХҮҮГҮЙ ЗЭЭЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГТАЙ ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ
ГЭРЭЭ БАЙГУУЛАВ



ОРОН НУТГИЙН БАГШ, АЖИЛЛАГСДЫГ УРТ ХУГАЦААНД
ДЭМЖИХ ХӨТӨЛБӨР



6 ОРОН СУУЦ

ОРОН НУТАГТ ШИНЭЭР ХИЙСЭН
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛ
/2017 ОНД/

4

ХУУЛЬ ДҮРМИЙН ЗӨРЧИЛ

“0”

МЭРГЭЖЛИЙН ШАЛГАЛТЫН
ҮНЭЛГЭЭ

90-95%



ХӨДӨЛМӨРИЙН АЮУЛГҮЙ БАЙДЛЫН
МАНЛАЙЛЛЫН ХӨТӨЛБӨР



“5A”

/АЖИЛЛАГСДЫН ХӨТӨЛБӨР/




“5M”

“SMART TL”

/МЕНЕЖЕРИЙН ХӨТӨЛБӨР/

АЮУЛГҮЙ БАЙДЛЫН СУРГАЛТ МЭДЭЭЛЭЛ



МЭРГЭЖЛЭЭС ШАЛТГААЛСАН ӨВЧИН



“0”

